



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/40

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 72 айлын орон сууцны барилгын гадна фасадны засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Гишүүдэд: Ш.Чанцалхүү - 6 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
Ц.Соёлмаа - Төрийн бус байгууллагын төлөөлөл
Ю.Ганбат - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Б.Бурмаа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ц.Даваасамбуу/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД